



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 10 сарын 12 өдөр

Дугаар A/197

Мандалговь


“Дижитал меппинг” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн A/18 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Газар усны нэр тодруулах (Гурвансайхан, Сайнцагаан, Говь-Угтаал, Өндөршил, Луус, Дэрэн)” зөвлөх үйлчилгээний багц-2 (Гурвансайхан сум, Өндөршил сум)-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Дижитал меппинг” ХХК-тай 19,798,000 (арван есөн сая долоон зуун ерэн найман мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Газар усны нэр тодруулах (Гурвансайхан, Сайнцагаан, Говь-Угтаал, Өндөршил, Луус, Дэрэн)” зөвлөх үйлчилгээний багц-2 (Гурвансайхан сум, Өндөршил сум) ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Дижитал меппинг” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Д.Түвшинбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Гурвансайхан сумын Засаг дарга (Л.Өлзийбат), Өндөршил сумын Засаг дарга (Л.Мөнхбадрах), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.



482060780